

01-1	Галт тэрэгний хуваарь хэт шахуу олон байх нь осол гарах аюултай.
01-2	Өндөгний хальс, дунгийн хясааг энд хаяарай.
01-3	Эгч дүү хоёрыг царай нь адилхан учраас ихэр гэж андуурав.
01-4	Сургуулийн төгсөлтийн ёслол дээр захирлын баяр хүргэж хэлсэн үг гүнзгий сэтгэгдэл төрүүлэв.
01-5	Япон улсын парламент нь төлөөлөгчдийн танхим, зөвлөхүүдийн танхим гэсэн бүтэцтэй.
01-6	Эмийн үр нөлөө нь 3 цагийн дараа мэдэгднэ байх.
01-7	Явах гэсэн зүгийнхээ эсрэг тал руу явдаг галт тэргэнд суучихжээ.
01-8	Хандивын мөнгийг албадан авах нь сайн юм биш.
01-9	150 жилийн өмнө Ёкохама нь хөдөөгийн загасчдын боомт байжээ.
01-10	Хотын захад асар их худалдааны төв байгуулагджээ.
01-11	Зөвшөөрөлгүй и-мэйл хүлээж авахаас татгалзах.
01-12	Ач тус болсон хүндээ ёс төртэй байхыг мартаж болохгүй.
01-13	Ямар ч барааг адилхан зуун иенээр зардаг дэлгүүр манай ойролцоо бий болов.
01-14	Одоохон миний ээлж ирэх учраас би биеэ барьж байна.
01-15	Жоом устгахын тулд өрөөндөө шавьжны хор тавив.
01-16	Эндээс дэнж рүү уруудаж явдаг учраас амар болно.
01-17	Чиглэлийн дугаарыг сайн харж, автобусанд суух.
01-18	Осол гаргасан автомашин нь эвдрэлтэй машин байжээ.
01-19	Манай айл өөр ажил хавсарч хийдэг тариачин айл.
01-20	Тэр бууж өгч, хоёр гараа өргөв.
01-21	Та зүгээр л дэргэд минь байгаа чинь сайхан байна.
01-22	Иллэгний шинэ машин. Чөлөөтэй туршиж үзнэ үү.
01-23	Би хамаатнаа бараадан Токиод ирлээ.
01-24	Навчны зүсэлтийн талбайг өсгөдөг шилээр ажиглая.
01-25	Тэр хоёр хүн бурхны өмнө хайртайгаа тангараглалаа.

02-1	Тэр эрэгтэй гарын алга урвуулахын адил хэлсэн үгнээсээ буцлаа.
02-2	Аавыгаа нас барлаа гэж цаг үргэлж гашуудаад байж боломгүй.
02-3	Ээж нь завгүй болоод хүүдээ анхаарал тавьж чадахгүй байлаа.
02-4	Хувцас хунараа нэг их юманд тоохгүй байдаг нь сайн юм биш.
02-5	30 жилийн дараах ангийнхаа уулзалтан дээр сургуулийнхаа дууг чин сэтгэлээсээ дуулав.
02-6	Химийн бодисыг маш болгоомжтой хадгалж хэрэглэж байгаа болов уу?
02-7	Аж үйлдвэр техникжин, ажиллах хөлс нь эрс багаслаа.
02-8	Энэ байдлаар цөлжөөд байвал, ихээхэн хэмжээний өлсгөлөн ч болж магадгүй.
02-9	Энэ хууль эмнээс хордсон өвчтнүүдэд туслахад зориулагджээ.
02-10	Тэр хүүхний дүр зоргоороо аашлах нь хэв хэмжээнээс хэтэрч байна.
02-11	Бодлоо орхиж, эвгүй юмсаа мартаа.
02-12	Ослын мэдээг сонсоод, тэр өрөөний уур амьсгал хэцүү болов.
02-13	Зовж зүтгэсний эцэст тэр хэцүү ажлыг арай гэж дуусгалаа.
02-14	Зовлон бэрхшээл хүнд байх тусмаа дараа ирэх жаргал нь их.
02-15	Хөл бөмбөгийн тэмцээн дуусахын өмнөхөн тэр хүн шийдвэрлэх нэг оноо хийлээ.
02-16	Бөөнөөрөө хамт яваа үед цаг сайн барих хэрэгтэй.
02-17	Орчин үед эдийн засаг, соёлын аль аль нь глабольчлагдаж байна.
02-18	Энэ зүйлийн талаар төв компани дээрээ авч очоод нягтлан үзнэ.
02-19	Миний охин дүү гэжүүн зантай учраас "уучлаарай" гэхгүй.
02-20	Багш байнга тэгш шудрага байр сууринаас хандах хэрэгтэй.
02-21	Эхний хагасаар дайрагдсан боловч сүүлийн хагасаар дайрч 3-ыг авав.
02-22	"Юуны өмнө бусдыг дээрэлхэж гадуурхах нь сайн юм биш."
02-23	Би зүүн баруун гар талын тэгш хэмтэй зураглал хийлээ.
02-24	Дан үгийг эгнүүлэн өрсөн төдийгөөр өгүүлбэр болохгүй.
02-25	Сүүлийн үед биеийн тамирын гутлын ул нь ойлт сайтай болсон.

03-1	Дэлхий дээрх байршлыг уртраг ба өргөргөөр тэмдэглэдэг.
03-2	Тэмдэг үйл үг гэдэг нь юмны байдал, хүний байдлыг тэмдэглэж "да"-гаар дуусдаг.
03-3	Цасан талст нь зургаанжин хэлбэртэй.
03-4	Сар хиртэх гэдэг нь сар дэлхийн сүүдэрт ороод, таллаж харагдах үзэгдэл юм.
03-5	Япон хүний олонх нь "даруу байх нь сайхан чанар" гэдэг.
03-6	Байгалийн шинжлэлийн хичээлийн туршилтаар өтгөн, шингэн давсны уусмал хийлээ.
03-7	Кокай гэдэг нь аль ч улсад харьяагдахгүй, чөлөөтэй явдаг далай юм.
03-8	Өнөөдрийн гүйлгээний мөнгөн дүнг гаргах.
03-9	Яриа хэлэлцээрийг амжилттай болгохын тулд захирал далдуур зохицуулжээ.
03-10	Алба амины хэргийг хольж хутгаж болохгүй.
03-11	Цагалбар нь нарных, сарных гэж хоёр янз байдаг, хуучны цагаан сарыг арынх нь цагалбараар хийдэг.
03-12	Энэ автомашиныг үйлдвэрлэлийн шат шатанд нямбайлан хийжээ.
03-13	Дэлхий өөрөө эргэсээр нарны эрхсийг тойрон эргэдэг.
03-14	ДОХ бол өвчний дархлал доройтох, олдмол өвчин юм.
03-15	Худалдаа, нийтийн хоол, нэвтрүүлэг гэх мэтийн үйлчилгээний ажил бол гуравдугаар аж үйлдвэр юм.
03-16	Энэ бар зургийн хар, цагаан өнгөний харьцуулалт сайхан.
03-17	Цагдаа нар алан хядагчдын эсрэг анхаарал сэрэмжээ өндөржүүлэв.
03-18	Ажил хийхдээ биеийн байрлал буруу байснаас ууц нуруу нь өвдөв.
03-19	Хамтран амьдарахад харилцан буулт хийх хэрэгтэй.
03-20	Супермакетаас 5 сүү, 10 кг будаа аваад гэртээ хүргүүллээ.
03-21	Үйлдвэрчний байгуулга, компани хоёрын хооронд цалин хөлсний хэлэлцээ тохиролцоонд хүрлээ.
03-22	Сурагчдын хороог сургуулийнхаа дүрэм өөрчлөх тухай багш нарын санаа бодол ямар байгааг туршиж үзлээ.
03-23	Тэр эрэгтэй нөхдийнхөө хүрээнээс гарч, үйлийн үрээ эдлэж байна.
03-24	Одоо Японд нийгмийн ажилд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хамтран оролцдог болгох гэж байна.
03-25	Цагдаагийн газар ДНК-г нь шалгасны үр дүнд түүнийг гэмтэн гэж тогтоолоо.